

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН 2019 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.12.20

Зуунмод

Нэг. Дотоод ажил

Бүх ажилчидтай хөдөлмөрийн гэрээг Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг байгуулж, багш дасгалжуулагчид ажилчид жил улирлын ажлын төлөвлөгөө, секц дугуйлангий төлөвлөгөө, хуваарийг баталгаажуулан, 2019 оны уралдаан тэмцээний нэгдсэн заавар удирдамжийг батлан сум, сургуулиудад хүргүүлсэн.

Байгууллагын орчин тойрны харуул хамгаалалтыг сайжруулах зорилгоор 8 камер шинээр байрлуулж, гадна пасад, гэрлэн чимэглэл хийх зорилгоор өөрийн нөөц бололцоогоо ашиглан гадна орчны гэрэлтүүлэг, спорт заалны гэрэлтүүлэг, олимпын өрөө, үүдний хэсгийн тохижилт, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор дулааны шугам хоолойг солих, зэрэг бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын жилийн ажлын хүрээнд байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, спортоор хичээллэгчдийн ая тухтай орчин нөхулийг нэмэгдүүлэхэд 16 сая төгрөгийг зарцууллаа



УИХ-ын гишүүн М.Энхболд Зуунмод суманд 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургалттай дунд сургуулийн барилгын шав тавилаа.



Мал төллөлтийн үед мал бүхий иргэдэд туслах зорилгоор жижүүр Б.Дашдаваад 10 хоног арга зүйч Д.Мөнх-Эрдэнэд 3 хоногийн цалинтай чөлөө олгож Баянцагаан, Бүрэн сумдад ажиллуулж 217 төл мал хүлээн авсан.



Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих өдрөөр байгууллын хашаанд 20 ш шар хуайс тарин хашаан доторх болон төв цэнгэлдэх хүрээлэнгийн хогийг цэвэрлэсэн.



Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Зуунмод сумын 4-р багийн 6 настай Энхжаргалын Наранжаргал хөгжлийн бэрхшээлтэй охинд БТСГ-ын гарын бэлэг гардуулсан.



Монголын тамирчдын өдөр, олон улсын олимпын өдрийг тохилдуулан Төв аймгийн БТСГ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019.06.22-ны өдөр зохион байгуулж спортын 4 төрлийн арга хэмжээнд 116 тамирчинг хамруулсан.



Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гаргаж дулааны шугам сүлжээнд засвар үйлчилгээг хийсэн.



Хоёр. Сургалт сурталчилгаа, нээлттэй хаалганы өдөрлөг

Төрийн албаны шинээр батлагдсан хуулийн талаар Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн хүний нөөцийн мэргэжлтэн Г.Мөнхгэрэл 2019-01-23-нд ирж сургалт зохион байгуулж 19 хүнээс 12 ажилтан албан хаагчид оролцлоо.



Чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид Баянцогт суманд ажиллаж хамтарсан бэлтгэл сургуулилт, 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан БТС-ын салбарын удирдах ажилтны сургалт 2019 оны 06-р сарын 30-наас 07-р сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдаж дарга Д.Алтанхуяг хамрагдлаа.



Биеийн тамирын багш, сурагчдын олимпиадыг 2019.04.10-нд зохион байгуулж 44 багш, 55 сурагч оролцож, онолын болон бие бялдрын шалгалтуудыг өгсөн.



Биеийн тамирын багш нарын сургалт семинартыг 2019.04.11-нд зохион явуулж 20 сумын 41 багш хамрагдсан



Зуунмод сумын 2-р багт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион явуулж 12 хүнд гарын авлага, тараах материал өгч, 8 хүнд алхалт гүйлтийг тогтмолжуулах, амьдралыг зөв хэв маягт суралцах талаар зөвлөгөө өгсөн.



“Спорт ба хөгжил сэдэвт” төвийн бүсийн аймгуудын БТС-ын салбарын ажилчдын сургалт зөвлөгөөн 2019 оны 05-р сарын 02-04-ны өдрүүдэд Өмнөговь аймгт зохион байгуулагдан төв аймгаас 11 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.



Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг 4 дүгээр баг дээр зохион байгуулж нийт 11 иргэдэд тараах материал, боршуур тарааж, байгууллагын үйл ажиллагаа, спортын секц дугуйлангын хуваарь болон иргэдэд эрүүл хооллолт, идэвхитэй хөдөлгөөний ач тус, нийгмийн эрүүл мэндийн өдрийн үйл ажиллагаандаа идэвхитэй оролцох талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.



Заамар, Шижир-Алт, Жаргалант, Зуунмод, Баянчандмань, Баян-Өнжүүл, Баянцагаан сумдад БТСГ, Номын сан, Музей, Театр хамтран нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 2600 гаруй иргэдтэй уулзалт хийж байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч санал, гомдлыг нь хүлээн авч шинээр гарсан ажлын байрны дасгалыг зааж сурталчилгааг хийсэн.



ББХЧ-ийн сорил судалгааны баг Баянжаргалан суманд 2019 оны 06-р сарын 16-нд ажиллаж сумын НБ-ын ажилтан, биеийн тамирын багш, эрүүл мэндийн төвийн ажилтнуудын сорил шивсэн байдалтай танилцан заавар зөвлөмж өгч ажилласан.



Гурав. Гадаа харилцаа хамтын ажиллагаа

Олимп, Дэлхийн аварга алдарт бөх Роман Михайлович Дмитриевичийн нэрэмжит ОХУ ын Саха улсын Биеийн тамирын их сургуултай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Төв аймгийн есвер вейн шигшээ багийнхан хамтарсан бэлтгэл, багш дасгалжуулагч солилцоо харилцан туршилга судлах зэрэгт ажиллахаар боллоо



Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд " KOICO" Олон улсын байгууллагаас ширээний теннис, жудо , фитнес, нийтийн биеийн тамирын чиглэлээр мэргэжилтэн багш ажиллаж, ширээний теннисний секц дугуйланг хичээллүүлж ,,,,, тамирчин хичээллэж байна.



БНСУ-ын Мичүхүл дүүргийн БТС-ын салбарын байгууллагуудын төлөөлөл 2019.07.24-нд Төв аймагт айлчилж спортын хэрэглэл материал тамирчин солилцоо, сургалт сурталилгааны талаар хамтран ажиллахаар тохиолцсон



Дэлхийн чөлөөт бөхийн холбооны судалгааны баг манай аймагт чөлөөт бөхийг хөгжүүлэх талаар судалж, хамтын ажиллагаа явуулах тухай гэрээ байгуулсан.



Төв аймгийн Шатрын Холбоо БНСУ-ын MSO KOREA байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, тус спортын байгууллагатай Биеийн тамир спортын газрын дарга уулзалт хийж, санал солилцон клубүүдийн үйл ажиллагаатай танилцаж, хоёр тал цаашид багш, дасгалжуулагч солилцох, Солонгос улсад зохиогдох шатрын тэмцээнд тамирчдаа оролцуулах, хамтарсан тэмцээн зохион явуулах, спорт-аялал жуулчлалын хөтөлбөр хэрэгжүүлэх, чиглэлээр хамтран ажиллахаар болсон.



**Дөрөв. Олон улсын болон улсын чанартай
зохион байгуулагдсан уралдаан тэмцээн**

Монголын масристингийн холбоотой хамтарч Арнольд Классик тэмцээний сонгон шалгаруулах тэмцээнийг 5 жингийн ангилалаар 2019-01-06-нд Зуунмод суманд зохион явууллаа. Тэмцээнд УБ, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Хэнтий аймгуудын 30 гаруй тамирчид оролцов.



“Шилдэг жү-до -2019” жү-до бөхийн олон хотын тэмцээнийг 2019.03.16-17-ны өдрүүдэд зохион явуулж 26 байгууллагын 420 гаруй тамирчид оролцлоо.



“Энх мэндийн харваа-2019” шагайн харвааны тэмцээн 2019.03.09-нд зохион байгуулагдаж 16 аймгийн 78 багийн 606 багийн харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.



Масристенгийн улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2019.05.08-09-ны өдрүүдэд зохион явуулж 2 улсын 15 байгууллагын 121 тамирчин оролцлоо.Орсоны холбооны Саха Якут улсаас 11 тамирчин ирж оролцсон.



“Алтан Заамар-2019” боксын олон улсын тэмцээнийг 2019.06.14-15-нд Заамар суманд зохион байгуулж 3 орны 21 байгууллагын 114 тамирчин оролцсон



Баянжаргалан сумын уугуул МУ-ын мэргэн Д.Өлзийбат агсаны нэрэмжит их сурын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2019.07.05-06-ны өдрүүдэд зохион байгуулж 18 аймгийн 28 багийн 503 харваач оролцсон



Богд хан уулын марафон олон улсын гүйлтийн тэмцээн 2019.07.28-нд зохион байгуулагдаж 5 орны 300 гаруй тамирчид хамрагдсан.



Тав. Нийтийн биеийн тамирын арга хэмжээ

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор ахмадын хөдөлгөөн эрүүл мэнд өдөрлөгийг Баянжаргалан, Өөрнуур, Эрдэнэсант 3 бүсэд зохион явуулж 27 сумын 406 ахмад хамрагдсан.



Зуунмод сумын ахмадуудын дунд хийн дасгалын тэмцээнийг 6-н багийн дунд зохион явуулж 120 ахмад хамрагдсан.



НЭМ-ийн өдрийг нарны алхалт, бүжиг, спорт тоглоом, иог бясалгал, хийн дасгал хэлбэрээр зохион байгуулж аймгийн хэмжээнд 14 удаа зохион явуулснаас Зуунмод сумын хэмжээнд 3204 хүн, 26 сумын 2044 хүн нийт 5597 хүнийг хамруулж.



Ланс уул гороолох явган аялалыг Зуунмод сумын 6 багийн ахмадуудын дунд Аймгийн Дашчойнхорлон хийдийн лам нартай хамтран зохион байгуулж ахмадуудын дунд граунд голфийн тэмцээнийг зохион явуулж 60 гаруй ахмадуудыг хамруулсан.




Зуунмод сумын 6-н багийн дунд "Хөдөлгөөн эрүүл мэнд сэдэвт" 5-н төрлийн тэмцээнийг зохион явуулж ХБИ-н хийсэн гар урлал, бүтээлээр үзсэглэн гаргаж харилцан туршлага солилцон 42 хүн оролцож авхаалж самбаа хурд хүчээ сорин өрсөлдсөн.




Зургаа. Сорил судалгаа

Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил судалгааг хавар, намарт 44262 хүнээс авч хамрагдвал зохих хүний 53.2%-ийг сорил судалгаанд хамруулан зохих түвшинд хүрсэн хүний тоо 16003 хүн ба өмнөх оны мөн үеэс 0.9 %-иар ахисан. Мөн 13-н байгууллагын 377-н ажилтан албан хаагчдаас сорил судалгааг биечлэн авч үнэлэлт дүгнэлт өглөө.





СОРИЛ СУДАЛГАА



Долоо. Зохион байгуулсан уралдаан тэмцээн:

Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 4 насны ангилалаар спортын 16 төрлөөр 21 арга хэмжээнд 11250 хүн, Хүүхдийн сортын наадмыг спортын 12 төрлөөр зохион явуулсан. 2019 онд нийтийн биеийн тамир, их спортын 386 арга хэмжээнд 53931 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 845 хүнээр нэмэгдсэн.





Найм. Онцлох ажил

1. Хүүхдийн спортын VI наадам

Хүүхдийн спортын наадмыг аймгийн хэмжээнд спортын 18 төрлөөр зохион явуулж 3818 хүүхдийг хамруулж улсын шигшээ тэмцээнд 23 төрлөөр 262 тамирчин оролцуулан 21 алт, 11 мөнгө, 37 хүрэл нийт 69 медаль хүртэж багийн дүнгээр улсын хэмжээнд 3-р байрыг эзэлсэн. Хүүхдийн спортын наадмын зохион явуулахад 14,1 сая, улсын уралдаан тэмцээнд оролцоход 15,7 сая нийт 36,1 сая төгрөгийг зарцуулсан. Хүүхдийн спортын наадмын цанын төрлөөр амжилттай уралдсан Жаргалант сумын тамирчин Батсүхийг Хонгор, Борнуур сумын тамирчин Дуламсүрэнгийн Урангоо нар нь Швецарь улсад болох “Lausanne2020” залуучуудын олимпийн наадамд оролцох эрхийг аваад байна.





2. Залуучуудын олимп

Хүүхдийн спортын наадмд цанын төрлөөр амжилттай уралдсан Жаргалант сумын тамирчин Батсүхийг Хонгор, Борнуур сумын тамирчин Дуламсүрэнгийн Урангоо нар нь Швецарь улсад болох “Lausanne2020” залуучуудын олимпийн наадамд оролцох эрхийг авч Швецарь улсыг зориоод байна. Б.Хонгор Швецарь улсад зохион байгуулагдсан өсвөрийн тамирчдын уралдаанд амжилттай оролцож олон улсын хэмжээний мастер, Д.Урангоо спортын мастерийн болзлыг биелүүлсэн.



3. Спортын төрөлжсөн сургалттай 640 хүүхдийн сургууль
 УИХ-ын гишүүн М.Энхболд Зуунмод суманд 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургалттай дунд сургуулийн барилгын шав тавигдан барилга угсралтын ажил эхэлсэн..



4. “ТӨВ+ “ ХӨГЖЛИЙН ЛИГ

Сагсан бөмбөгийн спортыг хөгжүүлэх, түүгээр хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, шилдэг тамирчдыг төрүүлэн гаргах зорилгоор ТӨВ+ хөгжлийн лигийг анх удаагаа зохион байгуулж 8 багийн 120 шилдэг тамирчид оролцож тойргийн 48 тоглолт, хагас шигшээ болн шигшээ 12 тоглолтыг явуулж Батмагнай ахлагчтай Амаржаргал дасгалжуулагчтай BROTHERS тэргүүлэн 5 сая төгрөгөөр шагнуулсан бол Ч.Оргил эзэнтэй, С.Наранхүү дасгалжуулагчтай, Б.Отгонбаяр ахлагчтай “ИРЭЭДҮЙ” баг 2-р байр, А.Доржпүрэв эзэнтэй, Н.Ганхуяг дасгалжуулагчтай, Н.Тэмүүлэн ахлагчтай BROTHER HOOD баг 3-р байруудыг эзэлсэн



5. СПОРТ ФОРУМ - 2019

Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй 21 холбоодын тэргүүн нарын дунд спорт форумыг зохион байгуулж 13 холбоодын дарга, нарийн бичгийн дарга нар хүрэлцэн ирж Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын эрдэм шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн докиор профессор Ш.Долгор шигшээ багийн сургалт дасгалжуулалтын талаар хичээл заалаа.



6. БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Баяндэлгэр, Мөнгөнморьт, Баянцогт, Алтанбулаг самдад 72 м2 бүхий спорт заалны барилга улсын төсөв ба орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж ашиглалтанд орлоо.



Баяндэлгэр сумын спорт заал



Алтанбулаг сумын спорт заал




Мөнгөнморьт сумын спорт заал



Баянцогт сумын спорт заал

Жаргалант сум орон нутгийн хөрөнгө оруулалтаар соёлын төвийн спорт заал болон ЕБС-ийн спорт зааланд иж бүрэн засвар үйлчилгээг хийсэн.



Аймгийн БТС-ын Газар